


МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН 2019-2023 ОНЫ ТАНИЛЦУУЛГА

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг нь 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д 10.2 хувийг, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт нь нийт экспортын орлогын 6.4 хувийг тус тус бүрдүүлж байна.

ЗУРАГ 1. ДНБ-Д ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИД

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 983.5 мянган өрх байгаагаас 189.3 мянга малчин өрх байгаа нь нийт өрхийн 19.2 хувийг эзэлж байна.

Мал тооллогын дүнгээр 2023 оны эцэст улсын хэмжээнд малтай 247.9 мянган өрх тоологдсон байна. Үүний 76.4 хувь буюу 189.3 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх байна.

ЗУРАГ 2. НИЙТ ӨРХӨД МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



ХҮСНЭГТ 1. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО

Үзүүлэлт	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
					Дүн	Хувь
Малтай өрх, мян.өрх	216.7	233.3	248.3	247.9	- 0.4	- 0.2
Малчин өрх, мян.өрх	153.1	171.6	190.8	189.3	- 1.5	- 0.8
Малчид тоо, мян.хүн	297.8	285.5	305.1	298.3	- 6.7	- 2.2


Малчин өрхийн тоо өмнөх оноос 1.5 мянга буюу 0.8 хувиар, малтай өрхийн тоо өмнөх оноос 0.4 мянга буюу 0.2 хувиар, малчдын тоо 6.7 мянга буюу 2.2 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 2. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2015			2019			2022			2023		
	Мал- тай өрх	Мал- чин өрх	Мал- чид	Мал- тай өрх	Мал- чин өрх	Мал- чид	Мал- тай өрх	Мал- чин өрх	Мал- чид	Мал- тай өрх	Мал- чин өрх	Мал- чид
	мянган өрх, мянган хүн											
Улсын дүн	216.7	153.1	297.8	233.3	171.6	285.5	248.3	190.8	305.1	247.9	189.3	298.3
Баруун бүс	59.9	39.0	79.2	63.8	41.3	70.5	66.3	46.6	77.0	66.2	46.2	74.4
Баян-Өлгий	14.6	8.9	18.4	14.9	8.7	13.7	15.8	10.2	15.8	15.8	10.1	15.2
Говь-Алтай	9.6	6.7	13.3	10.5	7.3	12.3	10.8	8.1	13.2	10.6	7.9	12.7
Завхан	12.2	8.3	16.1	13.4	8.9	15.6	13.9	9.9	16.6	13.8	9.6	15.8
Увс	12.1	8.0	16.2	13.0	8.9	16.0	13.5	10.0	17.5	13.7	10.1	17.3
Ховд	11.4	7.2	15.2	11.9	7.4	12.8	12.4	8.5	13.8	12.3	8.4	13.4
Хангайн бүс	79.4	63.0	123.1	85.7	69.9	119.2	89.4	76.7	126.0	89.6	76.6	124.7
Архангай	17.4	14.1	26.9	19.1	15.2	25.7	19.9	16.2	26.7	19.8	16.2	26.2
Баянхонгор	13.6	10.6	21.1	14.9	12.0	21.8	15.3	13.1	22.6	15.2	13.0	22.0
Булган	10.3	8.1	15.2	10.7	8.5	13.9	11.3	9.1	14.2	11.4	8.9	14.0
Орхон	1.1	0.8	1.4	1.1	0.8	1.3	1.4	1.0	1.4	1.4	1.0	1.4
Өвөрхангай	18.0	14.7	28.4	19.2	16.4	27.1	19.7	17.8	27.9	19.7	17.8	27.6
Хөвсгөл	19.0	14.8	30.1	20.6	16.9	29.4	21.9	19.5	33.4	22.2	19.7	33.5
Төвийн бүс	47.0	32.1	58.8	50.1	36.5	57.9	54.3	39.9	60.5	53.5	38.9	58.1
Говьсүмбэр	1.0	0.7	1.2	1.0	0.7	1.1	1.2	0.8	1.1	1.2	0.8	1.0
Дархан-Уул	2.4	1.1	2.1	2.3	1.3	1.7	2.2	1.2	1.7	2.1	1.2	1.6
Дорноговь	5.0	4.0	7.2	5.4	4.2	7.0	5.9	4.7	7.3	5.8	4.6	7.1
Дундговь	7.5	6.2	11.6	8.6	7.2	12.2	8.9	7.7	12.4	8.8	7.3	11.7
Өмнөговь	7.0	5.4	9.6	7.7	6.1	9.7	8.2	6.6	10.1	7.7	6.2	9.4
Сэлэнгэ	9.4	4.2	8.1	9.6	4.9	7.7	10.6	5.5	8.4	10.6	5.5	8.3
Төв	14.7	10.5	19.0	15.6	12.1	18.4	17.3	13.4	19.4	17.4	13.2	18.9
Зүүн бүс	25.3	17.8	34.5	29.0	21.2	34.3	33.1	24.2	37.1	33.2	24.2	36.7
Дорнод	6.3	4.0	7.7	7.6	5.3	8.0	9.2	6.2	8.4	9.3	6.1	8.3
Сүхбаатар	9.5	6.9	14.3	10.3	7.9	14.5	11.5	8.9	15.9	11.4	9.0	15.6
Хэнтий	9.5	6.9	12.5	11.1	8.0	11.8	12.5	9.1	12.8	12.5	9.1	12.8
Улаанбаатар	5.1	1.3	2.3	4.7	2.8	3.6	5.2	3.3	4.4	5.3	3.3	4.5

Нийт малчдын дунд залуу малчдын эзлэх хувь жилээс жилд буурсаар байна. Тухайлбал, 2015 онд нийт 297.8 мянган малчдын дотор 15-34 насны малчид 107.1 мянга буюу 36.0 хувь, 2019 онд нийт 285.5 мянган малчдын дотор 88.5 мянга буюу 31.0 хувь, 2022 онд нийт 305.1 мянган малчдын дотор 82.1 мянга буюу 26.9 хувийг тус тус эзэлж байсан бол 2023 онд нийт 298.3 мянган малчдын 76.7 мянга буюу 25.7 хувь болж, буурсан байна. Харин 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насны малчдын нийт дүнд эзлэх хувь тогтмол өссөөр байна.

ЗУРАГ 3. МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар

**МАЛТАЙ ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ.**

2023 онд малтай өрх 247.9 мянгад хүрсэн. Малтай өрхийг малын тоогоор бүлэглэвэл, 10 хүртэлх малтай өрх 14.0 мянга болж, нийт малтай өрхийн 5.7 хувийг, 11-30 малтай өрх 24.0 мянга болж, 9.7 хувийг, 31-50 малтай өрх 18.7 мянга болж, 7.5 хувийг, 51-100 малтай өрх 34.1 мянган болж, 13.8 хувийг, 101-200 малтай өрх 51.9 мянга болж, 20.9 хувийг, 201-500 малтай өрх 66.4 мянга болж, 26.8 хувийг, 501-ээс дээш малтай өрх 38.8 мянга өрх болж, 15.7 хувийг тус тус эзэлж байна. 200 хүртэлх малтай өрхийн тоо 2019 оноос хойш өсөж, 2023 онд нийт малтай өрхийн 57.6 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 6.1 мянган өрх буюу 4.5 хувиар өсжээ. Харин 200-500 толгой малтай өрх өмнөх оноос 0.9 мянгаар, 500 аас дээш малтай өрх 5.5 мянгаар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3. МАЛТАЙ ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ

Малын тооны бүлэг	Малтай өрхийн тоо				Малтай өрхийн малын тоо			
	2015	2019	2022	2023	2015	2019	2022	2023
	мянган өрх				сая толгой			
Бүгд	216.7	233.3	248.3	247.9	55.6	70.6	70.8	64.3
≤10	14.2	12.8	13.2	14.0	0.1	0.1	0.1	0.1
11-30	19.9	18.9	22.2	24.0	0.4	0.4	0.5	0.5
31-50	15.5	14.9	17.4	18.7	0.6	0.6	0.7	0.8
51-100	29.3	27.9	32.7	34.1	2.2	2.1	2.4	2.5
101-200	46.3	46.0	51.1	51.9	6.8	6.8	7.5	7.6
201-500	60.1	67.5	67.3	66.4	19.1	21.8	21.7	21.3
501-999	23.1	33.0	32.3	30.0	15.5	22.6	22.2	20.4
1000-1499	7.0	10.0	10.0	7.5	8.0	11.6	11.6	8.6
1500-2000	1.0	1.6	1.5	1.0	1.7	2.7	2.5	1.6
2001≤	0.5	0.7	0.6	0.4	1.2	1.9	1.6	1.0

Малын тооны бүлэг	Малтай өрхийн тоо				Малтай өрхийн малын тоо			
	2015	2019	2022	2023	2015	2019	2022	2023
	мянган өрх				сая толгой			
Дүнд эзлэх хувь								
Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
≤10	6.6	5.5	5.3	5.7	0.1	0.1	0.1	0.1
11-30	9.2	8.1	8.9	9.7	0.7	0.5	0.6	0.8
31-50	7.1	6.4	7.0	7.5	1.1	0.9	1.0	1.2
51-100	13.5	12.0	13.2	13.8	3.9	2.9	3.4	3.9
101-200	21.3	19.7	20.6	20.9	12.2	9.6	10.6	11.8
201-500	27.7	28.9	27.1	26.8	34.3	30.9	30.7	33.1
501-999	10.6	14.2	13.0	12.1	27.9	32.1	31.4	31.7
1000-1499	3.2	4.3	4.0	3.0	14.4	16.5	16.4	13.3
1500-2000	0.5	0.7	0.6	0.4	3.0	3.8	3.5	2.6
2001≤	0.2	0.3	0.3	0.2	2.2	2.6	2.2	1.5

Малын тоо. 2022 онд 71.1 сая толгой мал тоологдож, түүхэн дээд хэмжээнд хүрч байсан бол 2023 онд 64.7 сая толгой болж, өмнөх оноос 6.4 сая толгой буюу 9.1 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 4. МАЛЫН ТОО, төрлөөр

Малын төрөл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	мянган толгой				Дүн	Хувь
Бүгд	55 979.8	70 969.3	71 121.5	64 681.9	- 6 439.6	- 9.1
Адуу	3 295.3	4 214.8	4 821.1	4 829.7	8.6	0.2
Үхэр	3 780.4	4 753.2	5 512.8	5 350.8	- 162.1	- 2.9
Тэмээ	368.0	472.4	470.5	473.9	3.4	0.7
Хонь	24 943.1	32 267.3	32 747.7	29 409.4	- 3 338.3	- 10.2
Ямаа	23 592.9	29 261.7	27 569.4	24 618.2	- 2 951.2	- 10.7

2023 онд нийт малын тоо Орхон, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 5.4-352.6 мянган толгойгоор өсөж, бусад аймгуудад 14.2-1038.7 мянган толгойгоор буурсан байна.

ХҮСНЭГТ 5. МАЛЫН ТОО, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	мянган толгой				Дүн	Хувь
Улсын дүн	55 979.8	70 969.3	71 121.5	64 681.9	-6 439.6	- 9.1
Баруун бүс	13 711.2	16 004.3	16 131.0	14 316.2	-1 814.8	- 11.3
Баян-Өлгий	2 021.0	2 192.8	2 255.8	2 046.1	-209.7	- 9.3
Говь-Алтай	2 922.6	3 597.7	3 167.5	3 013.2	-154.3	- 4.9
Завхан	3 133.0	3 849.9	3 721.1	3 067.6	-653.5	- 17.6
Увс	2 729.1	3 279.6	3 513.8	2 994.5	-519.4	- 14.8
Ховд	2 905.4	3 084.3	3 472.9	3 194.9	-278.0	- 8.0
Хангайн бүс	20 481.6	26 246.5	24 513.0	17 452.5	-7 060.5	- 28.8
Архангай	4 457.1	6 167.0	5 886.1	4 847.4	-1 038.7	- 17.6
Баянхонгор	3 771.9	4 644.9	3 719.6	4 072.2	352.6	9.5
Булган	3 223.8	3 641.7	3 892.8	3 622.9	-270.0	- 6.9
Орхон	119.8	126.9	169.9	175.3	5.4	3.2
Өвөрхангай	4 511.0	5 625.5	4 590.4	4 734.7	144.3	3.1
Хөвсгөл	4 398.1	6 040.4	6 254.1	5 662.0	-592.1	- 9.5
Төвийн бүс	13 206.5	16 958.7	16 970.9	8 709.4	-8 261.6	- 48.7
Говьсүмбэр	379.5	452.0	464.3	450.1	-14.2	- 3.0
Дархан-Уул	288.4	347.4	313.2	261.3	-51.9	- 16.6
Дорноговь	1 801.2	2 404.2	2 909.7	2 294.8	-614.9	- 21.1
Дундговь	2 764.4	4 093.1	3 626.4	3 661.1	34.7	1.0
Өмнөговь	2 055.8	3 000.3	2 637.3	2 042.0	-595.3	- 22.6
Сэлэнгэ	1 458.7	1 682.5	1 912.3	1 769.4	-142.9	- 7.5
Төв	4 458.6	4 979.2	5 107.7	4 933.0	-174.7	- 3.4
Зүүн бүс	8 176.9	11 315.0	13 063.7	12 266.5	-797.1	- 6.1
Дорнод	1 555.4	2 629.6	3 342.3	3 151.7	-190.6	- 5.7
Сүхбаатар	3 070.3	3 817.0	4 644.8	3 859.5	-785.3	- 16.9
Хэнтий	3 551.2	4 868.4	5 076.6	4 401.0	-675.6	- 13.3
Улаанбаатар	403.7	444.9	442.8	427.2	-15.7	- 3.5

Сүргийн бүтцийг өмнөх онтой харьцуулан авч үзвэл, төл, өсвөр насны малын тоо өмнөх оноос 6.9 сая буюу 29.4 хувь, хээлтэгч мал 0.9 сая буюу 2.8 хувь, хээлтүүлэгч мал 41.8 мянга буюу 6.8 хувиар буурч, харин нас гүйцсэн эр малын тоо 1.4 сая буюу 8.5 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 6. НИЙТ МАЛЫН ТОО, сүргийн бүтцээр

Төрөл	2015	2019	2022	2023	2015	2019	2022	2023
	мянган толгой				хувь			
Бүгд	55 979.8	70 969.3	71 121.5	64 681.9	100.0	100.0	100.0	100.0
Төл, өсвөр насны	18 544.3	22 119.1	23 496.1	16 579.9	33.1	31.2	33.0	25.6
Нас гүйцсэн эр	13 107.6	17 326.1	16 158.6	17 539.2	23.4	24.4	22.7	27.1
Хээлтэгч	23 863.8	30 963.5	30 855.7	29 993.6	42.6	43.6	43.4	46.4
Хээлтүүлэгч	464.1	560.6	611.0	569.2	0.8	0.8	0.9	0.9

Малчин нэг өрхөд ногдох малын тоо. 2023 онд нэг малчин өрхөд ногдох малын тоо дунджаар 309 толгой болж, малын төрлөөр авч үзвэл, 22 адуу, 24 үхэр, 2 тэмээ, 142 хонь, 119 ямаа ногдож байна.

ХҮСНЭГТ 7. МАЛЧИН НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО

Малын төрөл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
					Дүн	Хувь
Бүгд	323	370	339	309	- 30	- 8.9
Адуу	19	22	22	22	0	0.3
Үхэр	20	23	25	24	- 1	- 2.8
Тэмээ	2	3	2	2	0	0.9
Хонь	146	169	157	142	- 15	- 10.0
Ямаа	136	153	132	119	- 13	- 10.5

Хээлтэгч мал. 2023 онд хээлтэгч малын тоо 30.0 сая толгойд хүрч, өмнөх оноос 862.1 мянган толгой буюу 2.8 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 8. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Малын төрөл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	мянган толгой				Дүн	Хувь
Бүгд	29 777.8	30 963.5	30 855.7	29 993.6	- 862.1	- 2.8
Гүү	1 291.6	1 388.8	1 607.1	1 704.3	97.2	6.0
Үнээ	1 755.3	1 900.6	2 203.9	2 193.6	- 10.3	- 0.5
Ингэ	161.0	167.4	173.5	177.0	3.5	2.0
Эм хонь	14 223.4	14 748.3	14 974.7	14 288.9	- 685.8	- 4.6
Эм ямаа	12 346.6	12 758.5	11 896.5	11 629.8	- 266.7	- 2.2

Хээлтэгч малыг төрлөөр авч үзвэл, гүү өмнөх оныхоос 97.2 мянган толгой буюу 6.0 хувиар, ингэ 3.5 мянган толгой буюу 2.0 хувиар өссөн бол үнээ 10.3 мянган толгой буюу 0.5 хувь, эм хонь 685.8 мянган толгой буюу 4.6 хувь, эм ямаа 266.7 мянган толгой буюу 2.2 хувиар буурсан байна. Хээлтэгч мал нийт малын 46.4 хувийг эзэлж байна. Төрлөөр авч үзвэл, адуун сүргийн 35.3 хувь, үхэр сүргийн 41.0 хувь, тэмээн сүргийн 37.4 хувь, хонин сүргийн 48.6 хувь, ямаан сүргийн 47.2 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь өмнөх оныхоос 3.0

нэгж хувиар өссөн байна. Хээлтэгч малын тоо бүх төрөл дээр өмнөх оноос 0.5-4.1 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 9. СҮРЭГТ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Малын төрөл	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
	хувь				Дүн	Хувь
Бүгд	53.2	43.6	43.4	46.4	3.0	-
Гүү	30.0	33.0	33.3	35.3	2.0	-
Үнээ	38.6	40.0	40.0	41.0	1.0	-
Ингэ	34.7	35.4	36.9	37.4	0.5	-
Эм хонь	44.9	45.7	45.7	48.6	2.9	-
Эм ямаа	42.7	43.6	43.2	47.2	4.1	-

Төл бойжилт. 2023 онд, оны эхний хээлтэгч малын 73.5 хувь буюу 22.7 мянган эх мал төллөж, гарсан төлийн 80.6 хувь буюу 18.3 мянган төл бойжуулсан байна. Бойжуулсан төл 2022 оноос 7.1 сая толгой буюу 27.9 хувиар буурсан байна. 2024 оны эхний улирлын байдлаар гарсан төлийн 90.1 хувь буюу 3.3 сая төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.9 хувь буюу 2.0 саяар буурсан байна.

ХҮСНЭГТ 10. БОЙЖУУЛСАН ТӨЛ, малын төрлөөр

Том малын зүй бус хорогдол. 2023 онд нийт 4.9 сая мал хорогдсон нь өмнөх оныхоос 7.4 дахин их байна.


ХҮСНЭГТ 11. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, малын төрлөөр

Малын төрөл	2015	2019	2022	2023	2024 I-III	Өөрчлөлт 2023/22	
	мянган толгой					Дүн	Хувь
Бүгд	626.5	1 117.6	667.5	4 921.5	6 308.7	4 254.0	7.4¹
Адуу	31.2	58.1	34.2	269.7	333.5	235.5	7.9 ¹
Үхэр	41.2	75.3	56.8	415.5	559.0	358.7	7.3 ¹
Тэмээ	1.9	2.1	2.0	8.8	3.1	6.8	4.4 ¹
Хонь	269.6	488.2	301.9	2 174.2	3 308.3	1 872.3	7.2 ¹
Ямаа	281.8	493.9	272.7	2 053.3	2 104.8	1 780.6	7.5 ¹

¹Дахин их

2024 оны эхний улиралд нийт 6.3 сая толгой мал хорогдсон нь оны эхний малын 9.8 хувийг эзэлж байна. Эхний улиралд хорогдсон нийт малын 5.3 хувь буюу 333.5 мянган толгой нь адуу, 8.9 хувь буюу 559.0 мянган толгой нь үхэр, 3.1 мянган толгой нь тэмээ, 33.4 хувь буюу 2.1 сая толгой нь ямаа, 52.4 хувь буюу 3.3 сая толгой нь хонь байна. Хорогдсон нийт мал 0.2 хувь нь чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг бусад шалтгаанаар хорогдсон бол 0.2 хувь нь өвчнөөр, 99.6 хувь нь аюулт үзэгдлээр хорогдсон байна. Аймгаар авч үзвэл, Сүхбаатар аймагт 1.6 сая мал хорогдсон нь нийт хорогдсон малын 24.7 хувь, Хэнтий аймагт 847.7 мянга буюу 13.4 хувь, Архангай аймагт 674.3 мянга буюу 10.7 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, нийт малд эзлэх хувиар, оноор



1990-2023 оны хооронд дунджаар 10 жил тутамд нэг удаа байгалийн аюулт үзэгдэл болж, тухай жилүүдэд оны эхний малын 6.4-23.4 хувь нь хорогдож байсан байна. Тухайлбал, 1993 онд оны эхний малын 6.4 хувь буюу 1.7 сая толгой, 2001 онд оны эхний малын 15.7 хувь буюу 3.5 сая толгой, 2010 онд оны эхний малын 23.4 хувь буюу 10.3 сая толгой, 2023 онд оны эхний малын 7.6 хувь буюу 4.9 сая мал хорогдсон байна. Эрчимжсэн аж ахуй 2015 онд нийт малтай өрхийн 1.1 хувь буюу 2.4 мянган малтай өрх эрчимжсэн аж ахуй эрхэлж байсан бол 2019 онд 3.7 мянган өрх буюу нийт малтай өрхийн 1.6 хувь, 2022 онд 4.4 мянган өрх буюу нийт малтай өрхийн 1.8 хувь, 2023 онд 4.6 мянган өрх буюу нийт малтай өрхийн 1.9 хувь болж, жилээс жилд нэмэгдсээр байна. Аймгаар авч үзвэл, эрчимжсэн мал аж ахуй Ховд, Дундговь, Баянхонгор, Увс, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг болон нийслэл Улаанбаатар хотод 2-399 өрхөөр нэмэгдсэн бол бусад аймагт буурсан үзүүлэлтэй байна.

ХҮСНЭГТ 12. ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙН ӨРХ, МАЛЫН ТОО, эзлэх хувь

Он	Нийт малын тоо	Эрчимжсэн аж ахуйн малын тоо	Эзлэх хувь	Нийт малтай өрхийн тоо	Эрчимжсэн аж ахуй эрхлэгч өрхийн тоо	Эзлэх хувь
	мянган толгой			мянган өрх		
2015	55 979.8	168.6	0.3	216.7	2.4	1.1
2019	70 969.3	357.9	0.5	233.3	3.7	1.6
2022	71 121.5	347.0	0.5	248.3	4.4	1.8
2023	64 681.9	327.1	0.5	247.9	4.6	1.9

Нийт эрчимжсэн чиглэлийн мал, амьтдын тоо өмнөх оныхоос 61.8 мянга буюу 3.4 хувиар буурсан байна. 150 151 Төрлөөр авч үзвэл, эрчимжсэн аж ахуйн махны үхэр өмнөх оноос 33.3 хувиар, сүүний үхэр 21.2 хувиар, мах, сүүний чиглэлийн үхэр 33.3 хувиар, махны чиглэлийн хонь 12.5 хувиар, сүүний чиглэлийн ямаа 24.3 дахин өссөн байна. Эрчимжсэн аж ахуйн өндөглөгч тахианы тоо өмнөх оноос 7.7 хувиар буурсан бол 2019 оноос 6.1 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 13. ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙН МАЛ, АМЬТДЫН ТОО, эзлэх хувь

Төрөл	Мал, амьтдын тоо			Дунд эзлэх хувь			Өөрчлөлт 2023/22	
	2019	2022	2023	2019	2022	2023		
	мянган толгой			хувь			Дүн	Хувь
Бүгд	579.1	1 832.6	1 770.6	100.0	100.0	100.0	- 61.8	- 3.4
Сүүний үхэр	25.3	25.0	30.3	4.4	1.4	1.7	5.3	21.2
Махны үхэр	11.7	15.6	20.8	2.0	0.9	1.2	5.2	33.3
Мах, сүүний үхэр	23.2	11.1	14.8	4.0	0.6	0.8	3.7	33.3
Махны хонь	13.5	6.4	7.2	2.3	0.3	0.4	0.8	12.5
Нарийн, нарийвтар ноосны хонь	10.5	19.5	16.1	1.8	1.1	0.9	- 3.4	- 17.4
Бүдүүн, бүдүүвтэр ноосны хонь	257.4	256.1	213.6	44.4	14.0	12.1	- 42.5	- 16.6
Мах, ноосны хонь	14.8	12.5	7.3	2.6	0.7	0.4	- 5.2	- 41.6
Сүүний чиглэлийн ямаа	1.6	0.7	17.0	0.3	0.0	1.0	16.3	24.3 ¹
Махны тахиа	0.0	38.1	123.7	0.0	2.1	7.0	85.6	3.2 ¹
Өндөглөгч тахиа	209.5	1 381.5	1 274.9	36.2	75.4	72.0	- 106.6	- 7.7
Гахай	8.1	11.6	6.3	1.4	0.6	0.4	- 5.3	- 45.7
Зөгий	1.6	3.9	7.5	0.3	0.2	0.4	3.6	92.3
Бусад	1.9	50.4	31.1	0.3	2.8	1.8	- 19.3	- 38.3

¹Дахин их

Дэлхийн малын тоо Дэлхийн малын тоо 2022 онд 4418.8 сая толгойд хүрч, Монгол Улсын нийт малын тоо үүний 1.7 хувийг эзэлж байна. Төрлөөр ангилж үзвэл, дэлхийн адууны 8.2 хувь, үхрийн 0.4 хувь, тэмээний 1.1 хувь, ямааны 2.9 хувь, хонины 2.1 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 4. ДЭЛХИЙН МАЛЫН ТООНД МОНГОЛ УЛСЫН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2022 оны байдлаар, хувиар



Манай улс дэлхийд адууны тоогоор 4-т, үхрийн тоогоор 51-т, тэмээний тоогоор 13-т, хонь, ямааны тоогоор тус бүр 11- т эрэмбэлэгдэж байна.

ХҮСНЭГТ 14. ДЭЛХИЙН МАЛЫН ТОО, 2022 оны байдлаар

д/д	Улсын нэр	Адууны тоо	д/д	Улсын нэр	Үхрийн тоо	д/д	Улсын нэр	Тэмээний тоо
	сая толгой							
1	АНУ	10.3	1	Бразил	234.4	1	Чад	10
2	Мексик	6.4	2	Энэтхэг	193.6	2	Сомали	7.5
3	Бразил	5.8	3	АНУ	92.1	3	Судан	5
4	Монгол	4.8	4	Этиоп	68	4	Кени	4.6
5	Казахстан	3.9	5	БНХАУ	61.2	5	Сауди Араб	2
6	БНХАУ	3.7	6	Аргентин	54.2	6	Нигери	1.9
7	Аргентин	2.5	7	Пакистан	53.4	7	Этиоп	1.5
8	Этиоп	2.2	8	Мексик	36.3	8	Мавритан	1.5
9	Колумб	1.6	9	Чад	35.7	9	Мали	1.3
10	Чад	1.5	10	Судан	32.3	10	Пакистан	1.1
11	ОХУ	1.3	51	Монгол	5.5	13	Монгол	0.5

ХҮСНЭГТ 15. ДЭЛХИЙН МАЛЫН ТОО, 2022 оны байдлаар, үргэлжлэл

д/д	Улсын нэр	Хонины тоо	д/д	Улсын нэр	Ямааны тоо
	сая толгой				
1	БНХАУ	194	1	Энэтхэг	150
2	Энэтхэг	75.3	2	БНХАУ	132.2
3	Австрали	70.2	3	Нигери	88
4	Иран	55.6	4	Пакистан	82.5
5	Нигери	50.3	5	Бангладеш	60
6	Чад	45.1	6	Этиоп	49.3
7	Турк	44.7	7	Чад	46.4
8	Судан	41.3	8	Кени	34.5
9	Этиоп	35.1	9	Судан	32.6
10	Их Британи	33.1	10	Мали	27.8
11	Монгол	32.7	11	Монгол	27.6